

PLITONIT A

Нэр: А

Тайлбар: ОХУ-ын стандарт хэмжилзүйн ГОСТ Р 56387 стандарт C0 T ангиллын дотоод заслын хавтангийн цавуу

Тэмдэглэгээ:



Бетон, төмөр бетон, үүрэн бетон, тоосго, цемент, шохой-цемент, гөлтгөнө шавардлагатай хана, шалны гадаргуу дээр 1% - иас багагүй ус шингээх чадвартай, 30х30 см-ээс ихгүй хэмжээтэй бүх төрлийн хавтанг хуурай болон чийгтэй өрөөнд наах зориулалттай. Цавуу нь хэрэглэхэд хялбар, усанд амархан холилддог, уян хатан чанар сайтай, гүйцэтгэлийн явцад хавтан нь сайн барьцалдах чадвартай тул босоо гадаргуугаас гулсдаггүй. Энэ нь дотор заслын байдлаар байранд, ялангуяа "барилгын компанийн засал" буюу халаалга өгөөгүй нөхцөлд ашиглахыг зөвлөнө. 1.5-аас 5 мм-ийн зузаантай өрлөгийн үеийн зузаантай силикат тоосго, хөөсөн хийбетон, хананы гадаргууг тэгшлэн тавихад тохиромжтой (нэг удаа түрхэн хэрэглэх үед давхаргын зузаан нь 10 мм хүртэл байна). ПЛИТОНИТ АнтиМороз -10°C хүртэл хөлдөлтөөс хамгаалах нэмэлттэй хамт хэрэглэж болно. Савлагаа 25 кг, 5 кг.

Давуу тал:

- Холих, түрхэхэд хялбар
- Босоо байрлалаас хуулралтын эсрэг барьцалдах чадвар өндөртэй
- 24 цагийн дараа явж, чигжээс хийж болно
- Усанд тэсвэртэй
- Өрлөгийн бүрэлдэхүүн болгон хэрэглэх

Бүтээгдэхүүний зарцуулалт

ойролцоогоор 1 мм зузаантай гүйцэтгэх үеийн зарцуулалтын хэмжээ нь 1,3 кг/м²

хавтангийн хамгийн урт талын урт, мм	108 хүртэл	109-200	201-250	251-300	300-аас эхлэн
хусуурын ховилын гүн, мм	4	6	8	10	12
хуурай хольцын зарцуулалт 1 м ² талбайд, кг-аар	2,65	3,98	5,3	6,63	7,95
25 кг цавуу ашиглан суурилуулсан хавтангийн талбай, м ² *-аас	9,4	6,3	4,7	3,8	3,1

* Материалын зарцуулалтын урьдчилсан тооцооны дундаж утгыг хүснэгтэд үзүүлэв. Бодит утга нь холих усны хэмжээ, төрөл, өнгөлгөөний доорх суурийн тэгш бус байдал, түүнчлэн бусад хүчин зүйлээс хамаарч өөр өөр байж болно.

Ажлын нөхцөл

Ажлын явц болон гүйцэтгэлээс хойших 3 хоногт агаарын температур +5 °C-аас +30 °C хооронд байх нь зохимжтой. Ажлын явцад зуурмагийн, суурийн болон хавтангийн температур, +10°C-аас +30°C хүртэл байх нь зохимжтой.

Суурийг бэлтгэх

Гадаргуу нь бат бэх байх шаардлагатай, ажил эхлэхээс өмнө гадаргууг сайтар цэвэрлэх (тоос, шороо, шохой, тос болон тослог гадаргуу, битум, органик болон эрдэс бүхий наалдамхай бодис, будгийн үлдэгдэл, түүнчлэн усанд уусдаг бодис) шаардлагатай. Гөлтгөнө суурь гадаргуу болон ус шингээх чадвар өндөртэй гадаргууг өнгөлөхдөө үйлдвэрлэгчийн зааврын дагуу ажил эхлэхийн өмнө PLITONIT хөрсжүүлэгчээр бүрсэн байх шаардлагатай. Цаашдын ажлыг хөрсжүүлэгч бүрэн хатсаны дараа гүйцэтгэнэ.

Зуурмагийн хольц бэлтгэх

Зуурмагийг бэлтгэхийн тулд энгийн ундны усыг ашиглана. Холих харьцаа нь 1 кг хуурай цавууны хольцод 0,19-0,24 литр (1 уут буюу 25 кг-д 4,75 - 6,0 литр) ус шаардагдана. Хуурай хольцыг тасалгааны температурт урьдчилан хэмжсэн зохих хэмжээний ус руу хийнэ, нэгэн төрлийн жигд болтол нь 2-3 минутын турш цахилгаан холигч эсвэл цахилгаан өрмийн тусламжтайгаар холино (эргэлтийн хурд нь 600 эрг/мин-ээс ихгүй байна). Зуурмагийг ойролцоогоор 5 минут амраан дахин холино. Энэ үед зөвшөөрөгдсөн хамгийн дээд хэмжээний үлдсэн усыг нэмж хэрэглэж болно. Бэлэн зуурмагийг хэрэглэх хугацаа нь 4 хүртэлх цаг байх бөгөөд агаарын хэт халалт болон нэвт салхижуулалт энэ хугацааг багасгахад нөлөөлнө.

Ажлын дараалал

Бэлтгэсэн зуурмагийг суурийн гадаргуу дээр жигд тараан, гөлгөр хусуураар түрхэж ховилтой хусуураар долгион гаргах байдлаар түрхэнэ (ховилын хэмжээ нь хавтангийн хэмжээ, төрлөөс хамаарна). Зуурмагийг асгаснаас хойш 10 минутын (ажил гүйцэтгэх хугацаа) дотор өнгөлгөөний хавтанг наах боломжтой байдлаар тооцон гүйцэтгэнэ. Хавтанг зуурмаг дээр тавихдаа бага зэрэг эргүүлэх байдлаар сайн дарж тавина. Хавтангийн байрлалыг 10 минутын дотор засан тохируулж болно. Өрөөний агааржуулалт, дулаан, гадаргуун чийг шингээх чадвараас шалтгаалан нээлттэй ажиллах хугацаа өөрчлөгдөж болно. Хэрэв хэрэглэсэн цавууны гадаргуу дээр хатсан царцдас үүссэн бол зуурмагийг гадаргуугаас хусаж аван шинээр сольж хийх шаардлагатай. Хавтан нь нээлттэй залгалтаар тавьж, зохих бэхэлгээгээр тэгшилнэ.

Анхааруулга

Өнгөлгөөний хавтанг гадаргуу дээр байрлуулснаас хойш 24 цагаас багагүй хугацааны дараа дээгүүр нь алхах, чигжээс хийж болно. Дээр заагдсан хугацаа нь орчны температур (20 ± 2)°C, агаарын харьцангуй чийгшил (60 ± 10)%-д үйлчлэх бөгөөд бусад температур-чийгшлийн үед энэ хугацаа хэлбэлзэж болно. Ажлыг гүйцэтгэхдээ барилгын ерөнхий ажил гүйцэтгэх зааварчилга, барилга угсралтын ажилд мөрдөгдөх аюулгүй ажиллагааны зааварчилга дагаж мөрдөх ёстой. Хавтанг тавихаас өмнө дэвтээж болохгүй, хавтангийн арын хэсгийг тоос, шорооноос цэвэрлэх хэрэгтэй. Ажил гүйцэтгэх явцад зуурмагийг үе үе хольж байх ёстой. Бэлэн зуурмаг дээр нэмж ус хийхийг хориглоно. Зуурмагийн өнгө өөр байх нь тухайн бүтээгдэхүүний түүхий эдийн олборлолтоос шалтгаалах бөгөөд энэ нь бүтээгдэхүүний техник үзүүлэлт болон ашиглалтын шаардлагад нөлөөлөхгүй. Найрлагад бага хэмжээний бэхжүүлэх утас агуулсан байж болно. Ажлыг хөнгөвчлөхийн тулд бид хавтан тэгшлэх системийг (ХТС) ашиглахыг зөвлөж байна.

Аюулгүй ажиллагаа

Хольц нь ОХУ-ын стандарт хэмжилзүйн газрын ГОСТ 12.1.007 стандартын дагуу аюулын 4-р (бага аюултай бодис) ангилалд хамаарна. Ажил гүйцэтгэхдээ бээлий, нүдний шил, амны хаалт хэрэглээрэй. Зуурмагийг арьс, нүдэнд хүрэхээс зайлсхийх. Нүдэнд хүргэсэн тохиолдолд нэн даруй их хэмжээний усаар зайлна. ХҮҮХДЭЭС ХОЛ БАЙЛГА!

Тээвэрлэлт болон хадгалах нөхцөл

Хуурай хольцыг ачаа тээвэрлэх дүрмийн дагуу бүрхүүлтэй тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ. Хуурай хольцтой уутыг савлагааны аюулгүй байдал, чийгээс хамгаалсан хаалттай хуурай өрөөнд хадгална. Үйлдвэрлэгчийн саванд хадгалах хугацаа нь тээвэрлэх, хадгалах нөхцөл зөрчигдөөгүй үед үйлдвэрлэсэн өдрөөс хойш 12 сар байна.

Орц, найрлага: Портландцемент, элс, полимер нэмэлт бүтээгдэхүүнүүд.

Үйлдвэрлэгчийн баталгаа

Хэрэглэгч тээвэрлэх, хадгалах нөхцөл, энэхүү гарын авлагад заасан зааврыг дагаж мөрдсөн тохиолдолд хольц нь техникийн үзүүлэлтүүдийн шаардлагад нийцэж байгааг үйлдвэрлэгч баталгаажуулна. Үйлдвэрлэгч нь материалтай ажиллах технологийг дагаж мөрдөхгүй байх, түүнчлэн эдгээр зааварт заагаагүй зорилго, нөхцөлд ашиглах үед хариуцлага хүлээхгүй. ОХУ-ын стандарт хэмжилзүйн ГОСТ 8.579-2002 стандартын дагуу цэвэр жингийн хазайлт байна. Бүтээгдэхүүнийг бүх төрлийн иргэний барилгад ашиглахыг зөвшөөрсөн (Аэфф<370 Бк/кг байх ОХУ-ын Цацрагийн аюулгүй байдлын стандартууд НРБ-99/2009, ариун цэврийн дүрэм, журам СанПиН 2.6.1.2523-09 нийцсэн).

Техник үзүүлэлтүүд

Хамгийн том дүүргэгч ширхгийн хэмжээ	0,63 мм
Цавууны үеийн хамгийн их залгааны зузаан	10 мм
1 кг хольцод хэрэглэх усны хэмжээ	0,19-0,24 л
25 кг хольцод хэрэглэх усны хэмжээ	4,75-6,0 л
Босоо гадаргуугаас хавтангийн гулгалт, багагүй	0,5 мм
Нээлттэй ажиллах хугацаа, багагүй	10 минут
Хавтанг засах, тохируулах хугацаа, багагүй	10 минут
Зуурмаг хольцын амьдрах чадвар	4 цаг
Ашиглалтын үеийн температурын горим, ихгүй	+50°C
Усан орчинд байлгасны дараа цавууны барьцалдах бат бөх байдал, МПа	≥0,5 МПа
Дээгүүр нь явж болох хугацаа, дараа	24 цаг

Хуурай агаарт 28 хоногийн турш байлгасны дараа цавууны барьцалдах бат бөх байдал.

Гадаргуутай бат бэх барьцалдах нээлттэй хугацаа 28 хоног хуурай хадгалалтын дараа

≥0,5 МПа

≥0,5 МПа

Чухал зөвлөмжүүд

Ажлын гүйцэтгэх хурд шаардлагатай байгаа нөхцөлд, байгууламжийг яаралтай ашиглалтад оруулах шаардлагатай үед бид ПЛИТОНИТ PLITONIT В экспресс хавтангийн хурдан хатуурдаг цавууг ашиглахыг зөвлөж байна. Том хэмжээтэй чулуун хавтанцарт тавихад PLITONIT В+, 600х600 хэмжээтэй чулуун хавтанцарт PLITONIT С цавуу хэрэглэх нь тохиромжтой. Шавар хавтанд цавуугаар хүчжүүлсэн утастай PLITONIT В, 450х450 чулуун хавтанцарт PLITONIT В+, 600х600 чулуун хавтанцарт PLITONIT С гантиг цавууг хэрэглэхийг зөвлөж байна. Шохойн чулуунд чулуун хавтанцар 600х600 PLITONIT В+, цавуу хэрэглэнэ.